



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

*Аймгийн ИТХ-ын захиалгаар Архангай аймаг дахь  
Төрийн аудитын газрын төлөвлөгөөний дагуу  
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан*



**ХУШ МОДНЫ САМАР ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОРИУЛАЛТААР БЭЛТГЭХ ГЭРЭЭГ  
ДҮГНЭЭГҮЙ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛААГҮЙ, ЗАРДЛЫН 34.6 ХУВИЙГ ҮР  
АШИГГҮЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

ЦЭЦЭРЛЭГ ХОТ  
2017 он

Аудитын тайланг  
бэлтгэсэн:

ҮАГ-ын харъяа  
Архангай аймгийн  
Аудитын газар

Дарга, Тэргүүлэх  
аудитор

Д.Уламбаяр

Утас: 70332141

Аудитын менежер

Т.Байгалмаа

Утас: 70332860

Ахлах аудитор

Д.Нэргүйбаатар

Утас: 70333019

Шинжээч

Ж.Мөнгөншагай

**Уг тайланг ҮАГ-ын  
Веб сайт-аас үзнэ үү.**

2017 оны 05 дугаар  
сар

Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар  
нэмж тодруулах, асууж  
лавлах зүйл байвал  
70332860 дугаар утас,  
70332141 дугаарын  
факсаар харилцана уу.

Хаяг: Архангай аймаг,  
Эрдэнэбулган сум, 3-р  
баг, аймгийн ЗДТГ-ын  
байр, А корпус, 3-р  
давхар 311 тоот өрөө

## АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Бүлэг 1. Хуш модны самар үйлдвэрлэлийн  
зориулалтаар бэлтгэсний төлбөрийг үнэн зөв  
ногдуулсан байна.

- 1.1. Хуш модны самар бэлтгэсний төлбөрөөр орон  
нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг  
урьдчилан тооцож төлөвлөх боломжгүй байна.
- 1.2. Гэрээ байгуулсан хуулийн этгээдүүдийг  
төлбөр төлөгчөөр бүртгэсэн байна.
- 1.3. Төлбөрийг хууль тогтоомжид заасан  
хэмжээгээр тооцож ногдуулсан байна.

Бүлэг 2. Гэрээнд заасан төлбөрийн орлогыг бүрэн  
төвлөрүүлээгүй, гэрээг дүгнээгүй, гэрээний  
хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч ажиллаагүй  
байна.

- 2.1. Гэрээ байгуулсан бүх хуулийн этгээдэд хууль  
тогтоомжид заасан төлбөрийг ногдуулсан байна.
- 2.2. Гэрээнд заасан төлбөрийг тухайн онд төсөвт  
бүрэн төвлөрүүлээгүй, байгуулсан гэрээг дүгнээгүй  
байна.
- 2.3. Эрх бүхий албан тушаалтнууд төлбөрийг хуульд  
заасан хугацаанд төвлөрүүлээгүй байна.

Бүлэг 3. Төсвийн үлдэгдэл, төлөвлөгөөнөөс давсан  
орлогын 34.6 хувийг зориулалт бус арвилан  
хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна.

- 3.1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялаг  
нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийг  
ихэнхдээ хуульд заасан хувь хэмжээгээр тооцон  
төлөвлөж батлуулаагүй байна.
- 3.2. Батлагдсан төсвийг зарим суманд зориулалт бус  
зарцуулсан байна.
- 3.3. Төсвийн үлдэгдэл, төлөвлөгөөнөөс давсан  
орлогын 34.6 хувийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй  
зарцуулсан байна.

ДҮГНЭЛТ

ЗӨВЛӨМЖ

Холбогдох байгууллагын санал  
Хавсралтууд

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

|                      |                                                                                              |
|----------------------|----------------------------------------------------------------------------------------------|
| <b>ААГ</b>           | АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР                                                               |
| <b>ҮАГ</b>           | ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР                                                                       |
| <b>ГА</b>            | ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ                                                                           |
| <b>ИТХ</b>           | ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ                                                                 |
| <b>УИХ</b>           | УЛСЫН ИХ ХУРАЛ                                                                               |
| <b>МУЗГ</b>          | МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР                                                                   |
| <b>БОНХС</b>         | БАЙГАЛЬ ОРЧИН НОГООН ХӨГЖЛИЙН САЙД                                                           |
| <b>АДБОУС</b>        | АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ                                                |
| <b>ААНБ</b>          | АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА                                                                    |
| <b>БОУБ</b>          | БАЙГАЛЬ ОРЧНЫ УЛСЫН БАЙЦААГЧ                                                                 |
| <b>ЗДТГ</b>          | ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР                                                                    |
| <b>СТСХ</b>          | САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС                                                                 |
| <b>БХНСЗ</b>         | БАЙГАЛЬ ХАМГААЛАХ НӨХӨН СЭРГЭЭХ ЗАРДАЛ                                                       |
| <b>ЗДНС</b>          | ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ САН                                                                        |
| <b>НДШ</b>           | НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ                                                                   |
| <b>ТБОНӨХБАҮХАТХ</b> | ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР<br>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬ |
| <b>ТЭЗҮ</b>          | ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ                                                                |

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

#### **1. Аудитын нэр:**

Архангай аймгийн Булган, Жаргалант, Хотонт, Төвшрүүлэх, Цэнхэр, Эрдэнэбулган, Тариат, Ихтамир сумын 2015, 2016 онд хуш модны самар үйлдвэрийн зориулалтаар бэлтгэсний төлбөр хураамжийг төсөвт төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалтын үр дүн

#### **2. Аудитын код:**

ААГ-/2017/01-ГА

#### **3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг аймгийн ИТХ-аас ирүүлсэн захиалга, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалаар баталсан Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

#### **4. Аудитын зорилтууд:**

Булган, Жаргалант, Хотонт, Төвшрүүлэх, Цэнхэр, Эрдэнэбулган, Тариат, Ихтамир сумын 2015, 2016 онд хуш модны самар үйлдвэрийн зориулалтаар бэлтгэсний төлбөр хураамжийг төсөвт төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалтын үр дүнд аудит хийж дүнг аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, ҮАГ-т танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ.Үүнд:

- Хуш модны самар үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэсний төлбөрийг хууль тогтоомжид заасны дагуу үнэн зөв ногдуулсан эсэх
- Дээрх орлогыг орон нутгийн төсвийн орлогын дансанд бүрэн төвлөрүүлсэн эсэх
- Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн энэхүү орлогыг хууль, тогтоомжид заасан зориулалтын дагуу үр дүнтэй, арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

#### **5. Аудитын хамрах хүрээ:**

Аудитаар Архангай аймгийн Булган, Жаргалант, Хотонт, Төвшрүүлэх, Цэнхэр, Эрдэнэбулган, Тариат, Ихтамир сумын 2015, 2016 онд хуш модны самар үйлдвэрийн зориулалтаар бэлтгэсний төлбөр хураамжийг төсөвт төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалт, үр дүнг сум бүрт холбогдох байгууллагын хүрээнд хамруулан шалгалаа.

#### **6. Үндсэн мэдээлэл:**

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “ойн дагалдах нөөц Ойн дагалт баялгийн нөөц **самар**, мөөг, давирхай, шилмүүс, мөчир, үр, хусны шүүсэнд төлбөр ногдуулна” гэж заажээ.

Аудитад хамрагдах сумдын 2015, 2016 төсвийн орлогын гүйцэтгэлийн тайлан, мэдээллийг шинжлэн судалж үзэхэд “байгалийн нөөц ашигласны төлбөр”-ийн орлого төлөвлөгөөнөөс их хэмжээгээр давж биелсэн байна. Тухайлбал:

- 2015 онд Цэнхэр сум 454.0 сая төгрөг, Хотонт 137.4 сая, Жаргалант 304.0 сая, Булган 200.7 сая, Ихтамир 45.0 сая, Эрдэнэбулган 2.0 сая, Төвшрүүлэх сум 1.3 сая төгрөгөөр тус тус төлөвлөгөөг давуулан биелүүлжээ.
- 2016 оны тухайд Булган сум 15.0 сая төгрөг, Жаргалант 106.0 сая төгрөг, Хотонт 221.5 сая төгрөг, Цэнхэр сум 355.2 сая төгрөг, Ихтамир 177.5 сая төгрөг тус тус төлөвлөгөөг давуулан биелүүлжээ.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого төлөвлөгөөнөөс давсан шалтгааныг судлан үзэхэд орлогын нэг төрөл болох **байгалийн ургамал ашигласны төлбөр буюу** хуш модны самар үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэсний төлбөрийн орлого төлөвлөгөөнөөс давж биелсэнтэй шууд холбоотой байна. Байгалийн ургамал ашигласны төлбөрийн /хуш модны самарын/ орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийг сум тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна.

**Байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилт /хүснэгт 1/**

| Сумын нэр    | 2015 он    |           |          | /Сая төгрөгөөр/<br>2016 он |           |        |
|--------------|------------|-----------|----------|----------------------------|-----------|--------|
|              | Төлөвлөгөө | гүйцэтгэл | Зөрүү    | төлөвлөгөө                 | гүйцэтгэл | зөрүү  |
| Булган       | 45.2       | 284.2     | 239.00   | 131.5                      | 172.3     | 40.80  |
| Жаргалант    | 99.9       | 435.8     | 335.90   | 102.1                      | 208.1     | 106.00 |
| Хотонт       | 53.1       | 200       | 146.90   | 144                        | 372.8     | 228.80 |
| Төвшрүүлэх   | 0.04       | 0.04      | 0.00     | 0.04                       | 0.5       | 0.46   |
| Цэнхэр       | 77.4       | 542.6     | 465.20   | 137.7                      | 489.4     | 351.70 |
| Эрдэнэбулган | 0          | 2         | 2.00     | 189.8                      | 187.8     | -2.00  |
| Тариат       | 0.073      | 0.3       | 0.23     | 34.1                       | 40.8      | 6.70   |
| Ихтамир      | 42.1       | 112.8     | 70.70    | 226.3                      | 420.2     | 193.90 |
|              | 317.813    | 1577.74   | 1259.927 | 965.54                     | 1891.9    | 926.36 |

Дээрх хүснэгтээс харвал аудитад хамрагдах нэр бүхий 8 суманд байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлого 2015 онд нийт 1259.9 сая төгрөгөөр, 2016 онд нийт 926.4 сая төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс давж биелсэн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмыг Байгалийн нөөц ашигласны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлан мөрдүүлж байна. Түүнчлэн дээрх орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх, арга хэмжээнд зарцуулах доод хэмжээний хязгаарыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт зааж өгсөн байна.

**Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын журам, Тэргүүлэх Аудиторын баталсан аудитын төлөвлөгөөнд үндэслэн, аудитын хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, судалгаа, тайлбар авах,

шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, давтан тооцоолох, анхан шатны баримтаас хөөн шалгах, бодитоор оршин байгаа эсэхийг үзэх буюу ажиглах зэрэг аудитын арга зүй горимуудыг ашиглав.

**Аудитын шалгуур:**

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Ойн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- МУЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоол: “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”
- Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2012 оны А-125 дугаар тушаал “Ойн дагалт нөөц ашигласны төлбөрийн хэмжээ тогтоох тухай”
- “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам” БОНХС-ын 2014 оны А/166 тушаал
- Байгаль орчин ногоон хөгжил, Аялал жуулчлалын сайдын 2015 оны А/338 дугаар тушаал:
- Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын 2016 оны А/17 тушаал
- Аймаг, сумын ИТХ-ын 2015, 2016 оны орон нутгийн төсөв батлах, орон төсвийн тодотгол хийх тухай тогтоолууд

**Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:**

Аудитыг аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Байгалмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд ахлах аудитор Д.Нэргүйбаатар, шинжээч Ш.Мөнгөншагай нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

**Аудитын хугацаа:**

Аудитыг 2017 оны 04 сарын 06-ны өдөр эхлүүлж 05 сарын 12-ний өдөр дуусгасан бөгөөд дарга, Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан Үндэсний Аудитын газар болон аймгийн ИТХ, аймгийн Засаг даргад хүргүүллээ.

**Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:**

Аудитын тайлан оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох газрын санал, түүнд хийсэн тайлбар, аудитын зөвлөмж, хавсралт гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Аудитын тайланд аудитын зорилго, зорилтод хариулт өгөхөд шаардагдах бүх нотлох зүйл, мэдээллийг хангалттай зохистой хэмжээгээр оруулсан болно.

Аудитын тайланг хамрагдсан шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулан саналыг авч, аудитын тайланг эцсийн байдлаар аймгийн Аудитын газрын Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж, Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан ҮАГ болон аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүллээ.

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.** ХУШ МОДНЫ САМАР ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОРИУЛАЛТААР БЭЛТГЭСНИЙ ТӨЛБӨРИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСНЫ ДАГУУ ҮНЭН ЗӨВ НОГДУУЛСАН БАЙНА.

1.1. Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх хуш модны самар бэлтгэсний төлбөрийн орлогыг урьдчилан тооцож төлөвлөх боломжгүй байна.

Хуш модны самарын ургалт нь байгаль цаг агаарын хүчин зүйлээс шалтгаалдаг бөгөөд газар зүйн байршил ургах самарын хэмжээ зэргийг дараа оны төсөв боловсруулах үед урьдчилан тооцож орлогыг тодорхойлох боломжгүй байна. БОНХС-ын 2014 оны А/166 дугаар тушаалаар баталсан "Ойн дагалт баялагийг хамгаалах, зохистой ашиглах журам"-ын 2.3<sup>1</sup>-д заасны дагуу тухайн жилийн ургацын байдлыг ойн анги судалж "Ойн судалгаа хөгжлийн төвд хүргүүлсний дараа Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн нутгаас хуш модны самар ашиглаж болох тухай шийдвэрийг гаргадаг байна. Үүнийг үндэслэн Ойн тухай хуулийн 38.5<sup>2</sup>-д заасны дагуу "самарын ургацаас хамаарч сумын ИТХ-аас Ойн тухай хуулийн 38.2<sup>3</sup>-д заасны дагуу ашиглах нөөцийн дээд хэмжээ, хязгаар, газар, байршил, зэргийг баталсны дараа тухайн жилийн төсвийн орлогыг нэмэгдүүлэн тодотгол хийсээр иржээ. Тухайлбал: аудитад хамрагдсан сумдын 2015 оны анх баталсан байгалийн ургамал ашигласны төлбөрийн /хуш модны самарын/ орлогын төлөвлөгөө ба гүйцэтгэлийн зөрүүг хүснэгтээр харуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 2.

Мянган төгрөгөөр

| Сумдын нэр   | Байгалийн орлогын |                  | ургамал                  | ашигласны | төлбөрийн | Зөрүү  |        |
|--------------|-------------------|------------------|--------------------------|-----------|-----------|--------|--------|
|              | Анх төлөвлөгөө он | баталсан 2015 он | Тодотгосон төлөвлөгөө он | Гүйцэтгэл |           |        |        |
| А            | 1                 |                  | 2                        | 3         |           | 4=3-1  | 5=3-2  |
| Жаргалант    | 0                 |                  | 99.9                     | 435.8     |           | 435.8  | 335.9  |
| Хотонт       | 0                 |                  | 53.1                     | 200.0     |           | 200.0  | 146.9  |
| Цэнхэр       | 0                 |                  | 77.4                     | 542.6     |           | 542.6  | 465.2  |
| Төвшрүүлэх   | 0                 |                  | 0.04                     | 0.04      |           | 0.04   | 0      |
| Булган       | 0                 |                  | 45.2                     | 284.2     |           | 45.2   | 239.0  |
| Ихтамир      | 0                 |                  | 42.1                     | 112.8     |           | 42.1   | 70.7   |
| Эрдэнэбулган | 0                 |                  | 0                        | 2.0       |           | 2.0    | 2.0    |
| Тариат       | 0                 |                  | 0.07                     | 0.31      |           | 0.31   | 0.24   |
| Дүн          |                   |                  | 317.8                    | 1577.8    |           | 1577.8 | 1259.9 |

Дээрх хүснэгт болон хууль, тогтоомжид зааснаас үзэхэд хуш модны самар үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэсэн төлбөрийн орлогыг өмнөх онд төсвийн

<sup>1</sup> Хуш модны самарын тухайд Ойн анги судлаж тогтоон "ойн судалгаа хөгжлийн төв" УТУГ-т самарын ургацын байдлын мэдээ, дүгнэлтийг тухайн оны 08 дугаар сарын 01-ний дотор хүргүүлнэ.

<sup>2</sup> Хушны самрын дунд ургацтай жилд зөвхөн ахуйн зориулалтаар, их ургацын жилд аль ч зориулалтаар ашиглахыг зөвшөөрнө"

<sup>3</sup> Энэ хуулийн 38.1-д заасан эрхийн бичигт иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, түүж бэлтгэх дагалт баялгийн төрөл, хэмжээ, хугацаа, газрын нэрийг заана.

төсөл боловсруулах үед урьдчилан тооцож төлөвлөх боломжгүй болох нь харагдаж байна.

Энэ талаар аудитад хамрагдсан сумын эрх бүхий албан тушаалтнуудаас ирүүлсэн тайлбарыг хавсаргав.

**1.2. Хуш модны самар ашиглах зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүдийг төлбөр төлөгчөөр бүрэн бүртгэж татварын албанд мэдээлсэн байна.**

Хуш модны самарын нөөц ашиглуулах тухай сумын ИТХ-ын шийдвэрийн дагуу сумын Засаг дарга нар “Ойн дагалт баялагийг хамгаалах, зохистой ашиглах журам”-ын 2.6<sup>4</sup>-д заасан мэргэжлийн эрх бүхий байгууллагуудтай уг журмын 2.14<sup>5</sup>-д заасны дагуу гэрээ байгуулан ажилласан байна. Харин сумын ИТХ, Засаг даргын шийдвэр, гэрээний дагуу дээрх журмын 2.2<sup>6</sup>-т заасан зөвшөөрлийг Байгаль хамгаалагч олгож иржээ.

Сум тус бүрийн гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн тоо, бэлтгэх нөөцийн хэмжээний нэгтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3.

| Сумын нэр           | 2015 он                                          |                                              |                                            | 2016 он                                          |                                              |                                            |
|---------------------|--------------------------------------------------|----------------------------------------------|--------------------------------------------|--------------------------------------------------|----------------------------------------------|--------------------------------------------|
|                     | Сумын ИТХ-аас тогтоосон нөөцийн дээд хэмжээ /тн/ | Зөвшөөрөл олгож гэрээ байгуулсан ААНБ-ын тоо | Гэрээнд заасан бэлтгэх нөөцийн хэмжээ /тн/ | Сумын ИТХ-аас тогтоосон нөөцийн дээд хэмжээ /тн/ | Зөвшөөрөл олгож гэрээ байгуулсан ААНБ-ын тоо | Гэрээнд заасан бэлтгэх нөөцийн хэмжээ /тн/ |
| <b>Жаргалант</b>    |                                                  | 7                                            | 1056.0                                     | 241.8                                            | 2                                            | 400                                        |
| <b>Цэнхэр</b>       | 1500                                             | 8                                            | 745                                        |                                                  | 6                                            | 605                                        |
| <b>Хотонт</b>       | 400                                              | 2                                            | 350                                        | 582                                              | 5                                            | 626                                        |
| <b>Ихтамир</b>      |                                                  | 6                                            | 290                                        | 800                                              | 4                                            | 660                                        |
| <b>Булган</b>       | 410                                              | 4                                            | 355                                        | 716                                              | 3                                            | 550                                        |
| <b>Тариат</b>       |                                                  | 0                                            | 0                                          |                                                  | 1                                            | 50                                         |
| <b>Эрдэнэбулган</b> |                                                  | 0                                            | 0                                          |                                                  | 4                                            | 234.7                                      |
| <b>Төвшрүүлэх</b>   |                                                  | 0                                            | 0                                          |                                                  | 0                                            | 0                                          |
|                     | 2310                                             | 27                                           | 2796                                       | 2339.8                                           | 25                                           | 3125.7                                     |

Дэлгэрэнгүйг хавсралт №1 –ээс үзнэ үү.

Дээрх /Хүснэгт 3/-ээс харвал зарим сумын ИТХ-аас тухайн суманд ашиглаж болох нөөцийн дээд хязгаарыг баталж мөрдүүлээгүй байгаа нь “Ойн дагалт баялагийг хамгаалах, зохистой ашиглах тухай журам”-ын 2.1-д заасныг хэрэгжүүлээгүй байна.

<sup>4</sup> Нөөцийг үйлдвэрлэлийн зориулалтаар зөвхөн ойн дагалт баялаг ашиглах хамгаалах, мэргэжлийн эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага, тухайн ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага бэлтгэнэ.

<sup>5</sup> Эзэмшлийн бүс ойд үйлдвэрлэлийн зориулалтаар нөөц ашиглуулах аж ахуйн нэгж байгууллагыг сумын Засаг дарга ойн ангитай зөвшилцөж сонгон гэрээ байгуулж, гэрээг дүгнэж ажиллана.

<sup>6</sup> Ойн анги /байхгүй бол тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч/ тухайн жилд бэлтгэх нөөцийн дээд хязгаарт багтаан иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагад зөвшөөрөл олгоно.

Иймд Сумдын Засаг дарга нарт тухайн жилд Сумын ИТХ-ын тогтоолоор баталсан хуш модны самрыг түүх, нөөцлөх дээд хязгаараас хэтрүүлэхгүй байх зөвлөмжийг хүргүүллээ.

Сумдын Засаг дарга нар Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23.1<sup>7</sup>-д заасны дагуу хуш модны самар бэлтгэх мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, төлбөрийн орлогыг сумын төсөвт төвлөрүүлэхийг сумын БОУБ ба сумын татварын байцаагчид үүрэг болгосон захирамж гаргаж ажилласан байна.

Энэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 4.3-д заасан “Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээллийг зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 10 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж гэрээ байгуулсан бүх ААНБ төлбөр төлөгчөөр бүртгэсэн гэж үзэхэд хүргэж байна.

**1.3. Төлбөрийг хууль тогтоомжид заасан хэмжээгээр тооцож ногдуулсан байна.**

Байгалийн баялаг ашигласны төлбөрийн тухай хуулийн 16.5<sup>8</sup> болон 11.2<sup>9</sup>-д заасны дагуу БОНХС-ийн 2012 оны А-125 тушаалаар хуш модны самарын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг дараах байдлаар тогтоосон байна.

Хүснэгт 4.

| №  | Нэр төрөл                                  | Ашиглалтын зориулалтаар, кг/төг |       |                |
|----|--------------------------------------------|---------------------------------|-------|----------------|
|    |                                            | Судалгаа, шинжилгээний          | Ахуйн | Үйлдвэрлэл ийн |
| 1. | Хуш модны самар<br>Pinus sibirica Du tour. | 500                             | 500   | 800            |

Аудитад хамрагдсан сумдын зөвшөөрөл олгож гэрээ байгуулсан ААНБ-дад ногдуулсан төлбөрийн хэмжээг гэрээнд тусгасан нөөцийн хэмжээгээр тооцож он тус бүрээр харуулбал дараах байдалтай байна.

2015 онд гэрээт ААНБ-аас төвлөрүүлэх орлогын судалгаа: Хүснэгт 5.

| Сумын нэр | Зөвшөөрөл олгож гэрээ | Гэрээнд заасан | Баталсан төлбөрийн | Гэрээний дагуу төсөвт |
|-----------|-----------------------|----------------|--------------------|-----------------------|
|-----------|-----------------------|----------------|--------------------|-----------------------|

<sup>7</sup> “Сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна.

<sup>8</sup> “Ойн дагалт баялгийн нөөцийг ашигласны төлбөрийн хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно”,

<sup>9</sup> Ойн дагалт баялгийн нөөцийг бэлтгэхэд хусны шүүсийг литрээр, бусад ойн дагалт баялгийн нөөцийг килограммаар тооцно”

|                     | байгуулсан<br>ААНБ-ын тоо | бэлтгэх<br>нөөцийн<br>хэмжээ /тн/ | хэмжээ<br>/тн/мян.төг/ | төлөх<br>төлбөрийн<br>хэмжээ<br>/мян.төг/ |
|---------------------|---------------------------|-----------------------------------|------------------------|-------------------------------------------|
| <b>Жаргалант</b>    | 7                         | 1056.0                            | 800.0                  | 844800.0                                  |
| <b>Цэнхэр</b>       | 8                         | 745                               | 800.0                  | 596000.0                                  |
| <b>Хотонт</b>       | 2                         | 350                               | 800.0                  | 280000.0                                  |
| <b>Ихтамир</b>      | 6                         | 290                               | 800.0                  | 232000.0                                  |
| <b>Булган</b>       | 4                         | 355                               | 800.0                  | 284000.0                                  |
| <b>Тариат</b>       | 0                         | 0                                 | 800.0                  | 0                                         |
| <b>Эрдэнэбулган</b> | 0                         | 0                                 | 800.0                  | 0                                         |
| <b>Төвшрүүлэх</b>   | 0                         | 0                                 | 800.0                  | 0                                         |
|                     | 27                        | 2796                              |                        | 2236800.0                                 |

2016 онд гэрээт ААНБ-аас төвлөрүүлэх орлогын судалгаа:

Хүснэгт 6.

| Сумын нэр           | Зөвшөөрөл<br>олгож гэрээ<br>байгуулсан<br>ААНБ-ын тоо | Гэрээнд<br>заасан<br>бэлтгэх<br>нөөцийн<br>хэмжээ /тн/ | Баталсан<br>төлбөрийн<br>хэмжээ<br>/тн/мян.төг/ | Гэрээний<br>дагуу төсөвт<br>төлөх<br>төлбөрийн<br>хэмжээ<br>/мян.төг/ |
|---------------------|-------------------------------------------------------|--------------------------------------------------------|-------------------------------------------------|-----------------------------------------------------------------------|
| <b>Жаргалант</b>    | 2                                                     | 400                                                    | 800.0                                           | 320000.0                                                              |
| <b>Цэнхэр</b>       | 6                                                     | 605                                                    | 800.0                                           | 484000.0                                                              |
| <b>Хотонт</b>       | 5                                                     | 626                                                    | 800.0                                           | 500800.0                                                              |
| <b>Ихтамир</b>      | 4                                                     | 660                                                    | 800.0                                           | 528000.0                                                              |
| <b>Булган</b>       | 3                                                     | 550                                                    | 800.0                                           | 440000.0                                                              |
| <b>Тариат</b>       | 1                                                     | 50                                                     | 800.0                                           | 40000.0                                                               |
| <b>Эрдэнэбулган</b> | 4                                                     | 234.7                                                  | 800                                             | 187760.0                                                              |
| <b>Төвшрүүлэх</b>   | 0                                                     | 0                                                      | 800                                             | 0                                                                     |
|                     | 25                                                    | 3125.7                                                 |                                                 | 2500560.0                                                             |

Дээрх 2 хүснэгтээс харахад зөвшөөрөл бүхий гэрээт ААНБ-уудад төлбөл зохих төлбөрийн хэмжээг БОНХС-ын 2012 оны А-125 тушаалаар батлагдсан хэмжээгээр тооцож ногдуулсан байна.

### Дүгнэлт

- Хушны самар үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэсний төлбөрийн орлогын хэмжээг өмнөх жилд урьдчилан тооцож төлөвлөж батлуулах боломжгүй байна.
- Зарим сумын ИТХ-аас хушны самарын нөөц бэлтгэх дээд хязгаарыг батлаагүй байна.
- Зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагуудтай хууль, тогтоомжийн дагуу гэрээ байгуулан ажиллаж, төлбөр төлөгчөөр бүрэн бүртгэсэн байна.
- Хуш модны самар үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэсний төлбөрийг гэрээ байгуулсан бүх ААНБ-уудад хууль тогтоомжид заасан хэмжээгээр үнэн зөв ногдуулсан байна.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ.** ХУШ МОДНЫ САМАР ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОРИУЛАЛТААР БЭЛТГЭСЭНД НОГДУУЛСАН ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ ТАЙЛАНТ ОНД ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ, ГЭРЭЭГ ДҮГНЭЭГҮЙ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ АВААГҮЙ БАЙНА.

**2.1. Гэрээ байгуулж зөвшөөрөл авсан бүх хуулийн этгээдийг төлбөр төлөгчөөр бүртгэж төлбөр ногдуулсан байна.**

Аудитад хамрагдсан 8 сумын гэрээ байгуулсан ААНБ-н тоо, бэлтгэх нөөцийн хэмжээ, гэрээгээр ногдуулсан төлбөрийн хэмжээ зэргийг он тус бүрээр нэгтгэж харуулбал дараах байдалтай байна. Хүснэгт 7.

| 2015 он                       |                                      |                                           | 2016 он                       |                                      |                                           |
|-------------------------------|--------------------------------------|-------------------------------------------|-------------------------------|--------------------------------------|-------------------------------------------|
| Гэрээ байгуулсан ААНБ-ийн тоо | Бэлтгэх самрын нөөцийн хэмжээ /тонн/ | Төсөв төвлөрүүлэх төлбөрийн дүн /сая.төг/ | Гэрээ байгуулсан ААНБ-ийн тоо | Бэлтгэх самрын нөөцийн хэмжээ /тонн/ | Төсөв төвлөрүүлэх төлбөрийн дүн /сая.төг/ |
| 27                            | 2796                                 | 2236.8                                    | 25                            | 3125.7                               | 2500.6                                    |

Хуш модны самар үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэхээр сумын Засаг дарга нартай гэрээ байгуулсан дээрх ААНБ-уудын төлбөрийн тухай дэлгэрэнгүйг нэгдүгээр бүлгийн 1.2 дахь хэсгээс үзнэ үү.

**2.2. Гэрээнд заасан төлбөрийг тухайн онд бүрэн төвлөрүүлээгүй, гэрээг дүгнээгүй байна.**

Аудитад хамрагдсан сумдын хуш модны самар үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласны төлбөрийн орлогыг төсөвт төвлөрүүлсэн байдлыг он тус бүрээр авч үзвэл:

**Хүснэгт 8. 2015 он:**

| Сумын нэр    | Зөвшөөрөл олгож гэрээ байгуулсан ААНБ-ын тоо | Гэрээнд заасан бэлтгэх нөөцийн хэмжээ /тн/ | Гэрээний дагуу ногдуулсан төлбөрийн хэмжээ /сая.төг/ | Төсөвт төвлөрүүлсэн орлого /сая.төг/ | Дутуу төвлөрүүлсэн орлого /сая.төг/ |
|--------------|----------------------------------------------|--------------------------------------------|------------------------------------------------------|--------------------------------------|-------------------------------------|
| Жаргалант    | 7                                            | 1056.0                                     | 844.8                                                | 412.3                                | 432.5                               |
| Цэнхэр       | 8                                            | 745                                        | 596.0                                                | 542.4                                | 53.6                                |
| Хотонт       | 2                                            | 350                                        | 280.0                                                | 200.0                                | 80.0                                |
| Ихтамир      | 6                                            | 290                                        | 232.0                                                | 112.8                                | 119.2                               |
| Булган       | 4                                            | 355                                        | 284.0                                                | 284.0                                | 0                                   |
| Тариат       | 0                                            | 0                                          | 0                                                    | 0                                    | 0                                   |
| Эрдэнэбулган | 0                                            | 0                                          | 0                                                    | 0                                    | 0                                   |
| Төвшрүүлэх   | 0                                            | 0                                          | 0                                                    | 0                                    | 0                                   |
|              | 27                                           | 2796                                       | 2236.8                                               | 1551.5                               | 685.3                               |

**Хүснэгт 9. 2016 он:**

| Сумын нэр | Зөвшөөрөл олгож гэрээ байгуулсан | Гэрээнд заасан бэлтгэх нөөцийн | Гэрээний дагуу ногдуулсан төлбөрийн | Төсөвт төвлөрүүлсэн орлого /сая.төг/ | Дутуу төвлөрүүлсэн орлого /сая.төг/ |
|-----------|----------------------------------|--------------------------------|-------------------------------------|--------------------------------------|-------------------------------------|
|-----------|----------------------------------|--------------------------------|-------------------------------------|--------------------------------------|-------------------------------------|

|              | ААНБ-ын<br>тоо | хэмжээ<br>/тн/ | хэмжээ<br>/сая.төг/ |        |       |
|--------------|----------------|----------------|---------------------|--------|-------|
| Жаргалант    | 2              | 400            | 320.0               | 208.0  | 112.0 |
| Цэнхэр       | 6              | 605            | 484.0               | 484.0  | 0     |
| Хотонт       | 5              | 626            | 500.8               | 372.8  | 128   |
| Ихтамир      | 4              | 660            | 528.0               | 420.2  | 107.8 |
| Булган       | 3              | 550            | 440.0               | 172.3  | 267.7 |
| Тариат       | 1              | 50             | 40.0                | 40.0   | 0     |
| Эрдэнэбулган | 4              | 234.7          | 187.8               | 187.8  | 0     |
| Төвшрүүлэх   | 0              | 0              | 0                   | 0      | 0     |
|              | 25             | 3125.7         | 2500.6              | 1885.1 | 615.5 |

Дээрх 2 хүснэгтээс харахад нөөц бэлтгэж төсөвт төвлөрүүлэхээр байгуулсан гэрээний дүнгээс 2015 онд 685.3 сая төгрөг, 2016 онд 615.5 сая төгрөгийг тус тус дутуу төвлөрүүлсэн харагдаж байна.

Энэ нь дараах шалтгаантай байна. Үүнд:

1. “Ойн дагалт баялагийг хамгаалах, зохистой ашиглах” журмын 2.8-д заасны дагуу зөвшөөрлийг эрхийн бичгээр олгох бөгөөд энэ журмын 2.12-д заасны дагуу эрхийн бичгийн 1 дүгээр хувь нь санхүүгийн тооцооны баримт болно. Иймд эрхийн бичгийн дүн нь бэлтгэсэн нөөцийн хэмжээ ба төсөвт төлсөн төлбөрийн дүнгийн нотлох баримт болж байна.
2. Холбогдох эрх бүхий албан тушаалтнуудаас ирүүлсэн тайлбараас харахад гэрээний 2.6-д заасан нөхцөл үүссэн буюу самарын нөөц дууссанаас гэрээнд заасан хэмжээний самар бэлтгэж чадаагүй байж болзошгүй байна.
3. Бэлтгэсэн самарыг тээвэрлэхдээ эрхийн бичгийн хамт тээвэрлэдэг буюу эрхийн бичигт заасан хэмжээний нөөцийг тээвэрлэдэг байна.
4. Гэрээнд бэлтгэх хугацаа он дамжин хэрэгжихээр зааснаас зарим ААНБ-д дараа онд төлбөрөө төлсөн байна. Тухайлбал: Булган, Жаргалант, Хотонт сумдууд АСНЕФ ХХК, Буман боргоцой ХХК, Тэнүүн зоргол ХХК-тай 2016.09.12, 2016.09.13, 2016.09.28-нд тус тус гэрээ байгуулсан бөгөөд тус компаниуд нь 2017 онд нөөцөө бэлтгэж гэрээний дагуу төлбөрөө хийсэн байна. 2017 онд орсон төлбөрийг харуулбал:
  - АСНЕФ ХХК нь гэрээний дагуу Булган сумын төсвийн орлогын дансанд 200.0 сая төгрөгийг,
  - Буман боргоцой ХХК нь гэрээний дагуу Жаргалант, Хотонт сумдын төсвийн орлогын дансанд тус бүр 40.0 сая төгрөгийг,
  - Тэнүүн зоргол ХХК нь гэрээний дагуу Хотонт сумын төсвийн орлогын дансанд 88.0 сая төгрөгийг тус тус төсөвт тушаасан байна.

Хэдийгээр гэрээнд заасан төлбөрийг тухайн онд төвлөрүүлээгүй нь дээрх шалтгаантай холбоотой боловч сумын Засаг дарга нар ААНБ-уудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангуулах, гэрээг дүгнэх арга хэмжээ аваагүй нь энэ орлогын төвлөрүүлэлтэнд хяналт тавьж ажиллаагүй гэж үзэхэд хүргэж байна. Иймд аудитаас гэрээний хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулах, гэрээг дүгнэж хэвших зөвлөмжийг холбогдох сумын Засаг дарга нарт хүргүүлэхээр шийдвэрлээд байна.

### 2.3. Эрх бүхий албан тушаалтан төлбөрийг хуульд заасан хугацаанд төвлөрүүлж гэрээг дүгнээгүй байна.

Сумын Засаг дарга нар тухайн сумаас хуш модны самар үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх ААНБ-тай гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих, төлбөрийг төсөвт төвлөрүүлэх үүргийг сумын БОУБ, татварын байцаагч нарт хариуцуулан захирамж гаргасан байна.

Гэтэл ААНБ-уудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг шалгах, гэрээг дүгнэх арга хэмжээг дээрх албан тушаалтнууд авч ажиллаагүй буюу сумын Засаг даргын захирамжийг хэрэгжүүлээгүй байна.

Сумын Засаг даргын захирамжийг хэрэгжүүлж ажиллаагүй холбогдох албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Харин тухайн онд төвлөрүүлсэн орлогын тайлан, тооцоог сумын татварын байцаагч, санхүүгийн албаны дарга нар жил бүр аймгийн Татварын хэлтэс ба ЗДТГ-ын СТСХ-ийн орлогын мэргэжилтнээр хянуулж баталгаажуулсан байна .

#### **Дүгнэлт**

- Гэрээ байгуулж төлбөр төлөгчөөр бүртгэгдсэн ААНБ-уудад төлбөрийг бүрэн ногдуулсан байна.
- Гэрээ байгуулсан ААНБ-д гэрээний дагуу орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, байгуулсан гэрээг дүгнэж гэрээний хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авч ажиллаагүй байна.

#### **Зөвлөмж**

- Гэрээний хугацаа дуусахад гэрээг дүгнэж хэвших, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулах талаар хуульд заасан арга хэмжээг авч ажиллах
- Сумын БОУБ хуш модны самарын нөөц ашигласны төлбөрийн орлогын тооцоог хийж эцсийн тооцоог сумын татварын байцаагч, сумын санхүүгийн албаны даргатай хийж баталгаажуулан баримтжуулж байх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. 2015 ОНЫ ТӨСВИЙН ҮЛДЭГДЭЛ ДАВСАН ОРЛОГЫН 34.6 ХУВИЙГ АРВИЛАН ХЭМНЭЛТГҮЙ, ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

#### 3.1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялаг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийг зарим суманд хуульд заасан хэмжээгээр тооцон төлөвлөж батлуулаагүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтоож өгсөн байна.

---

Байгалийн баялгийн нөөц ашигласны  
төлбөрийн орлогын төрөл

---

Байгаль орчныг хамгаалах, байгалийн  
нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд  
зарцуулах төлбөрийн орлогын

---

|                                                       | хувь, хэмжээний доод хязгаар /нийт орлогын дүнгээс хувиар/ |
|-------------------------------------------------------|------------------------------------------------------------|
| 1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого | 15 хувь                                                    |
| 4. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого                | 85 хувь                                                    |

Аудитад хамрагдсан сумдын 2015 оны байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл ба 2016 оны төсөвт байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулахаар хуваарилж баталсан зардлын хэмжээг харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 10.

| Сумын нэр | 2015 оны төвлөрүүлсэн орлого /гүйцэтгэлээр/ | 2016 оны төсөвт суулгасан БХНС зардлын хэмжээ | Зардлын орлогод ногдох хувь | Хуульд заасан хувь, доод хязгаар | Зөрүү буюу дутуу хувь |
|-----------|---------------------------------------------|-----------------------------------------------|-----------------------------|----------------------------------|-----------------------|
| Жаргалант | 435.8                                       | 39.5                                          | 9.06                        | 15                               | 5.94                  |
| Булган    | 284.2                                       | 42.6                                          | 15.0                        | 15                               | 0                     |
| Хотонт    | 200                                         | 19.8                                          | 9.90                        | 15                               | 5.10                  |
| Цэнхэр    | 542.6                                       | 85.2                                          | 15.70                       | 15                               | -0.70                 |
| Ихтамир   | 112.8                                       | 25.9                                          | 22.96                       | 15                               | -7.96                 |
|           | 1575.4                                      | 213.0                                         | 13.52                       | 15.00                            | 1.48                  |

Дээрх хүснэгтээс харахад Жаргалант, Хотонт сум хуульд заасан хэмжээгээр байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлыг төлөвлөж зарцуулж чадахгүй байна.

3.2. 2015 оны төсвийн зарцуулаагүй үлдэгдэл, давсан орлогыг зарим суманд зориулалт бус зүйлд зарцуулсан байна.

Төсвийн үлдэгдэл ба төлөвлөгөөнөөс давсан орлогын судалгаа  
Хүснэгт 11.

| № | Сумдын нэр   | 2015 оны төсвийн үлдэгдэл, давсан орлого | Үүнээс           |                |
|---|--------------|------------------------------------------|------------------|----------------|
|   |              |                                          | Төсвийн үлдэгдэл | Давсан орлого  |
|   | А            | 1=2+3                                    | 2                | 3              |
| 1 | Жаргалант    | 333.5                                    | 21.6             | 311.9          |
| 2 | Цэнхэр       | 526.2                                    | 17.2             | 509.0          |
| 3 | Хотонт       | 144.0                                    | 1.0              | 143.0          |
| 4 | Ихтамир      | 85.7                                     | 43.5             | 42.2           |
| 5 | Булган       | 193.3                                    | 3.4              | 189.9          |
| 6 | Тариат       | 26.3                                     | 10.7             | 15.6           |
| 7 | Төвшрүүлэх   | 6.7                                      | 0.3              | 6.4            |
| 8 | Эрдэнэбулган | 27.6                                     | 3.8              | 23.8           |
|   | <b>Дүн</b>   | <b>1,343.3</b>                           | <b>101.5</b>     | <b>1,241.8</b> |

Аудитад хамрагдсан сумдын 2015, 2016 оны байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө ба гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

**Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогын  
төлөвлөгөөний хэрэгжилт**

| Хүснэгт 12.  |            | /Сая төгрөгөөр/ |          |            |           |        |  |
|--------------|------------|-----------------|----------|------------|-----------|--------|--|
| Сумын нэр    | 2015 он    |                 |          | 2016 он    |           |        |  |
|              | Төлөвлөгөө | гүйцэтгэл       | Зөрүү    | төлөвлөгөө | гүйцэтгэл | зөрүү  |  |
| Булган       | 45.2       | 284.2           | 239.00   | 131.5      | 172.3     | 40.80  |  |
| Жаргалант    | 99.9       | 435.8           | 335.90   | 102.1      | 208.1     | 106.00 |  |
| Хотонт       | 53.1       | 200             | 146.90   | 144        | 372.8     | 228.80 |  |
| Төвшрүүлэх   | 0.04       | 0.04            | 0.00     | 0.04       | 0.5       | 0.46   |  |
| Цэнхэр       | 77.4       | 542.6           | 465.20   | 137.7      | 489.4     | 351.70 |  |
| Эрдэнэбулган | 0          | 2               | 2.00     | 189.8      | 187.8     | -2.00  |  |
| Тариат       | 0.073      | 0.3             | 0.23     | 34.1       | 40.8      | 6.70   |  |
| Ихтамир      | 42.1       | 112.8           | 70.70    | 226.3      | 420.2     | 193.90 |  |
|              | 317.813    | 1577.74         | 1259.927 | 965.54     | 1891.9    | 926.36 |  |

Байгалийн ургамал ашигласны төлбөрөөр төсөвт оруулсан орлогын зарцуулалтын тухайд зөвхөн тухайн орлогыг хэрхэн зарцуулсныг зардлын зүйлээр шалгах боломжгүй юм. Өөрөөр хэлбэл тухайн орлого нь нийт орлогын дүнд орж сумын ИТХ-аар батлагддаг бөгөөд энэ орлогын дүнг тусад нь зарцуулахаар батладаггүйтэй холбоотой байна. Урьд оны төсвийн үлдэгдлийг сумын ИТХ-аар хэлэлцэж төсвийн тодотголд тусган зарцуулсан байна./дэлгэрэнгүй сум тус бүрийн ИТХ-ын тогтоолоос харна уу/

Сум тус бүр харилцан адилгүй олон төрлийн зардалд өмнөх оны төсвийн үлдэгдэл, давсан орлогыг зарцуулахаар хуваарилан баталсан байна. (Сум тус бүрийн баталсан зардлыг жагсаалтыг хавсралт №2-аас үзнэ үү.) Бид эдгээр зардлыг дараах зардлын бүлгээр нэгтгэн авч үзлээ.

Хүснэгт 13.

| Сумын нэр | Сумын ИТХ-аар баталсан 2015 оны төсвийн үлдэгдэл, давсан орлого | Зардлын төрөл нийтлэг |                                      |                            |            |                                 |
|-----------|-----------------------------------------------------------------|-----------------------|--------------------------------------|----------------------------|------------|---------------------------------|
|           |                                                                 | Хөрөнгө оруулалт      | Төсөвт байгууллагуудын урсгал зардал | Сумын ИТХ-ын суудлын мөнгө | ЗДНөөц сан | Байгаль хамгаалах нөхөн сэргээх |
| Цэнхэр    | 526.2                                                           | 187                   | 72.2                                 |                            | 167        | 100                             |
| Булган    | 193.3                                                           | 99.1                  | 45.6                                 | 6                          |            | 42.6                            |
| Хотонт    | 144                                                             | 105.8                 | 7.3                                  | 5.5                        | 5.5        | 19.9                            |
| Ихтамир   | 85.7                                                            | 40.8                  | 17.1                                 |                            | 1.9        | 25.9                            |
| Тариат    | 10.5                                                            |                       | 10.5                                 |                            |            |                                 |
| Жаргалант | 263.5                                                           | 164.5                 | 39.3                                 | 2.1                        | 18.1       | 39.5                            |

1257.5      597.2      226.3      13.6      192.5      227.9

Жич: 2016 оны давсан орлогын зарцуулах хуваарь аудит хийх явцад батлагдаагүй байсан болно.

График 1.



Зарцуулалтыг ИТХ-ын баталсан зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг шалгахад Ихтамир суманд ИТХ-аар батлаагүй цагдаагийн торгуулийн “машин” худалдан авахад 2.5 сая төгрөг, Эрдэнэ толгой багийн төвийн урсгал засварт 0.5 сая төгрөгөөр батлагдсан хэмжээг хэтрүүлэн зарцуулсан зөрчил илэрлээ. Бусад суманд ийм зөрчил илрээгүй.

Зардлын гүйцэтгэлийг нэгтгэж хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 14.

| Сумын нэр    | Гүйцэтгэл   | Үүнээс: Зардлын төрөл нийтлэг |                                      |                            |            |                                 |
|--------------|-------------|-------------------------------|--------------------------------------|----------------------------|------------|---------------------------------|
|              |             | Хөрөнгө оруулалт              | Төсөвт байгууллагуудын урсгал зардал | Сумын ИТХ-ын суудлын мөнгө | ЗДНөөц сан | Байгаль хамгаалах нөхөн сэргээх |
| А            | 2=3+4+5+6+7 | 3                             | 4                                    | 5                          | 6          | 7                               |
| Цэнхэр       | 448.2       | 167.6                         | 68                                   | 0                          | 127.4      | 85.2                            |
| Булган       | 184.7       | 92.7                          | 43.4                                 | 6                          | 0          | 42.6                            |
| Хотонт       | 144         | 105.8                         | 7.4                                  | 5.5                        | 5.5        | 19.8                            |
| Ихтамир      | 73.5        | 32.8                          | 15.1                                 | 0                          | 1.8        | 23.8                            |
| Тариат       | 10.5        |                               | 10.5                                 |                            |            |                                 |
| Жаргалант    | 164.4       | 91.5                          | 22.7                                 | 2.1                        | 18.1       | 30                              |
| Төвшрүүлэх   | 6.6         |                               | 5.6                                  |                            | 1          |                                 |
| Эрдэнэбулган | 27.6        |                               | 27.6                                 |                            |            |                                 |

|      |        |       |       |      |       |       |
|------|--------|-------|-------|------|-------|-------|
| Нийт | 1059.5 | 490.4 | 200.3 | 13.6 | 153.8 | 201.4 |
| Хувь | 100    | 46.3  | 18.9  | 1.3  | 14.5  | 19.0  |

Аудитад хамрагдсан 8 суманд урьд оны төсвийн үлдэгдэл давсан орлого нийт 1257.5 сая төгрөгийг зарцуулахаар баталснаас гүйцэтгэлээр нийт 1059.5 сая төгрөгийг зарцуулжээ. Үүнээс хамгийн их буюу 46.3 хувийг хөрөнгө оруулалтын шинжтэй үндсэн хөрөнгө худалдан авах, их ба урсгал завсар хийхэд зарцуулсан байна.

3.3. Төсвийн үлдэгдэл, давсан орлогын зарим хэсгийг арвилан хэмнэлтгүй үр ашиггүй зүйлд зарцуулсан байна.


Зардлын төлөвлөгөө ба гүйцэтгэлийг харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна. Хүснэгт 15.

| Сумын нэр    |           |                     | Үүнээс: Зардлын төрөл нийтлэг    |                                     |               |                                          |       |        | Зарцуулаагүй<br>үлдэгдэл |
|--------------|-----------|---------------------|----------------------------------|-------------------------------------|---------------|------------------------------------------|-------|--------|--------------------------|
| Төлөвлөгөө   | Гүйцэтгэл |                     |                                  |                                     |               |                                          |       |        |                          |
|              |           | Хөрөнгө<br>оруулалт | Төсөвт<br>байгууллагын<br>урсгал | Сумын<br>ИТХ-ын<br>суудлын<br>мөнгө | ЗДНөөц<br>сан | Байгаль<br>хамгаалах<br>нөхөн<br>сэргээх |       |        |                          |
|              |           | А                   | 1                                | 2=3+4+5<br>+6+7                     | 3             | 4                                        | 5     | 6      |                          |
| Цэнхэр       | 526.2     | 448.2               | 167.6                            | 68                                  | 0             | 127.4                                    | 85.2  | 78     |                          |
| Булган       | 193.3     | 184.7               | 92.7                             | 43.4                                | 6             | 0                                        | 42.6  | 8.6    |                          |
| Хотонт       | 144       | 144                 | 105.8                            | 7.4                                 | 5.5           | 5.5                                      | 19.8  | 0      |                          |
| Ихтамир      | 85.7      | 73.5                | 32.8                             | 15.1                                | 0             | 1.8                                      | 23.8  | 12.2   |                          |
| Тариат       | 10.5      | 10.5                |                                  | 10.5                                |               |                                          |       | 0      |                          |
| Жаргалант    | 263.5     | 164.4               | 91.5                             | 22.7                                | 2.1           | 18.1                                     | 30    | 99.1   |                          |
| Төвшрүүлэх   | 6.7       | 6.6                 |                                  | 5.6                                 |               | 1                                        |       | 0.1    |                          |
| Эрдэнэбулган | 27.6      | 27.6                |                                  | 27.6                                |               |                                          |       | 0      |                          |
|              | 1257.5    | 1059.5              | 490.4                            | 200.3                               | 13.6          | 153.8                                    | 201.4 | 198.00 |                          |

Дээрх хүснэгтээс харахад нийт 1059.5 сая төгрөг буюу батлагдсан зардлын 84.3 хувийг тайланд онд зарцуулсан байна.

Нийт зарцуулалтын дүнд зардлын зүйлээр нэгтгэж бүлэглэсэн зардлын төрлийн эзлэх хувийг харуулбал: График 2.


## Нийт зардлын бүтэц



- Дээрх дүрслэлээс харахад нийт зарцуулалтын 18.9 хувийг төсөвт байгууллагын цалин, НДШ, бичиг хэрэг, албан томилолт, тэтгэмж, урамшуулал зэрэг зардалд, 14.5 хувийг баяр, ёслол, тэмдэглэлт ой, буцалтгүй тусламж олгох зэрэг Засаг даргын нөөц сангийн зардалд, 1.3 хувийг намуудад суудлын мөнгө олгоход зэргээр нийт 34.8 хувь буюу 367.7 сая төгрөгийг урсгал шинжтэй зардалд зарцуулсан нь төсвийг арвилан хэмнэлтгүй үр ашиггүй зарцуулж **“Хэмнэлтийн горимд шилжих”** тухай МУЗГ-ын 2014 оны 147 дугаар тогтоол, Сангийн Сайдын 2014 оны 122 дугаар тушаалыг зөрчсөн гэж үзэхэд хүргэж байна.
- Харин нийт зарцуулалтын 46.3 хувь болох хөрөнгө оруулалтын шинжтэй 490.4 сая төгрөгийн зарцуулалтыг авч үзвэл: /Дэлгэрэнгүйг Хавсралт №3-аас үзнэ үү./

График 1.

## Хөрөнгө оруулалтын шинжтэй зардлын бүтэц



Хамгийн их буюу 51 хувийг үндсэн хөрөнгийн их засварт, 43 хувийг барилга байгууламж, тоног төхөөрөмж, автотээврийн хэрэгсэл шинээр худалдан авахад, 6 хувийг үндсэн хөрөнгийн урсгал засварт зарцуулсан байна.

2015 оны төсвийн үлдэгдэл, давсан орлогын зарцуулалтаар хийсэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг 4 суманд газар дээр нь очиж шалгахад дараах зөрчлүүд илрээд байна. Үүнд:

Цэнхэр сумын тухайд:

- Засаг даргын тамгын газар 2015 оны давсан орлогоор Ойн ангийн конторын барилгыг 40.0 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулан худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 29.2<sup>10</sup> дэх хэсэг, ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 3.1<sup>11</sup> “33.1<sup>12</sup> дэх хэсэгт заасныг тус зөрчсөн байна.

Дээрх зөрчлийн улмаас тухайн барилгын ашиглалттай холбоотой урсгал зардлыг жил бүр сумын төсвөөс санхүүжүүлэхээр болж тухайн сумын төсөвт ачаалал үүсгэж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан “Төсвийг арвилан хэмнэлттэй үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

- 2015 оны давсан орлогоор 2016 онд барьж ашиглалтанд оруулсан хогийн цэгийн харуулын байшин нь галд шатаж ашиглах боломжгүй болжээ. Галын шалтгааныг мэргэжлийн байгууллагаар шалгуулаагүй бөгөөд барилгыг дахин ашиглах талаар арга хэмжээ аваагүйн улмаас төсвийн хөрөнгө үр дүнгүй болж балгас болон орхигдсон байна.
- цэцэрлэгт хүрээлэн бий болгох 6.1 сая төгрөгийн ажил техникийн тодорхойлолтонд нийцээгүй, чанарын шаардлага хангахгүй, гэрээ дүгнээгүй.
- Төсөвт байгууллагуудын хэрэгцээнд зориулж 28.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хууль зөрчин шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Ихтамир сумын тухайд

- Сумын ЗДТГ-т 1.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсныг хөрөнгийн бүртгэл тайланд тусгаагүй орхигдуулсан байна.

### Дүгнэлт

- Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялаг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийг зарим суманд хуульд заасан хэмжээгээр тооцон төлөвлөж батлуулаагүй байна.
- Давсан орлогын 34.8 хувийг урсгал зардлыг санхүүжүүлэхэд олгож төсвийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна.

### Зөвлөмж

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос тухайн төрлийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан доод хэмжээнээс багагүй байхаар төлөвлөж батлуулан зарцуулах

<sup>10</sup> “Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна”

<sup>11</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө”

<sup>12</sup> “Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно.”

- Төсөвт байгууллагын урсгал зардлыг санхүүжүүлэхээр батлахгүй байх, Тэвчиж болох зардлыг хэмнэх тухай ЗГ-ын 2014 оны 147 дугаарыг тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

### **АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ**

- Хуш модны самар үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэсний төлбөрийн орлогын хэмжээг урьдчилан тооцон төлөвлөж батлуулах боломжгүй байна.
- Зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагуудтай хууль, тогтоомжийн дагуу гэрээ байгуулан ажиллаж, татварын алба төлбөр төлөгчийг бүрэн бүртгэсэн байна.
- Хуш модны самар үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэсний төлбөрийг гэрээний дагуу хууль тогтоомжид заасан хэмжээгээр үнэн зөв ногдуулсан байна.
- Хуш модны самар үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх гэрээг дүгнэж гэрээний хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авч ажиллаагүй байна.
- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг хуульд заасан хувь хэмжээгээр тооцон төлөвлөж зарцуулаагүй байна.
- Хөрөнгийг сумын ИТХ-аар баталсан зардлын зориулалтын дагуу зарцуулсан боловч арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зүйлд зарцуулсан байна.

Аудитаар нийт 136.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.7 сая төгрөгийг төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 135.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 4 албан шаардлагыг хүргүүлээд байна.

Мөн урьд оны төсвийн үлдэгдэл, давсан орлогын зарцуулалтын байдалд дүн шинжилгээ хийж үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах саналыг аймгийн ИТХ-д уламжиллаа.

### **АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

Хотонт, Төвшрүүлэх, Цэнхэр, Жаргалант, Булган, Ихтамир, Тариат, Эрдэнэбулган Сумын засаг дарга нарт

- Гэрээний хугацаа дуусахад гэрээг дүгнэж хэвших, гэрээний үүргийг хэрэгжилтийг хангуулах талаар хуульд заасан арга хэмжээг авч ажиллах
- Сумын БОУБ хуш модны самарын нөөц ашигласны төлбөрийн орлогын тооцоог хийж эцсийн тооцоог сумын татварын байцаагч, сумын санхүүгийн албаны даргатай хийж баталгаажуулан баримтжуулж байх.
- Тухайн жилд хуш модны самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх гэрээ байгуулахдаа сумын ИТХ-ын тогтоосон нөөцийн дээд хязгаараас хэтрүүлэхгүй байх
- Хуш модны самрын үйлдвэрлэх, нөөцлөх тусгай зөвшөөрөлтэй, зөвшөөрлийн хугацаа дуусаагүй ААНБ-тай хамтран ажиллах, гэрээ байгуулах
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос тухайн төрлийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан доод хэмжээнээс багагүй байхаар төлөвлөж батлуулан зарцуулах

- Хуш модны самрын орлого гэх мэт урьдчилан тооцож төлөвлөх боломжгүйгээс их хэмжээгээр төлөвлөгөөнөөс давж биелэснээс үүссэн орлогыг захиран зарцуулахдаа тооцоо судалгаанд үндэслэн Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан “төсвийг арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” зарчмыг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв, урсгал зардал, төсөвт учруулах ачаалал зэргийг тооцон санхүүжүүлэхээр төлөвлөх
- Төсөвт байгууллагын урсгал зардлыг санхүүжүүлэхээр батлахгүй байх, Тэвчиж болох зардлыг хэмнэх тухай ЗГ-ын 2014 оны 147 дугаарыг тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

### ***Аймгийн ИТХ-д уламжлах санал***

Сумын төсвийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогын тодорхой хувийг аймгийн ТЭЗ-ийн дансанд төвлөрүүлж дахин хуваарилах замаар орон нутагт хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай ТЭЗҮ, зураг төсөв нь хийгдсэн санхүүжилтийн эх үүсвэр дутагдалтайгаас хэрэгжээгүй байгаа арга хэмжээнд зарцуулахаар бодлогын түвшинд судалж үр дүнтэй үр ашигтай зарцуулах арга хэмжээ авах, шийдвэр гаргах нь зүйтэй гэж үзлээ.

Тайлан боловсруулсан:

Шинжээч

Ахлах аудитор

Ж.Мөнгөншагай

Д.Нэргүйбаатар

Хянасан:

Аудитын менежер

Т.Байгалмаа

Холбогдох байгууллагын санал:



МОНГОЛ УЛС  
АРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

65139 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас: 7033-3208, Факс: 7033-3208

2017.05.18 № 01/649

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Санал хүргүүлэх тухай

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

а/а Нарангуй Гасуун

Санал хүргүүлэх.

2017.05.18

Архангай аймгийн зарим суманд 2015, 2016 онд хуш модны самар үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэсэн төлбөр хураамжийг төсөвт төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалтанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

“Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам”-ын 2.13-т “нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын гэрээгээр эзэмшиж буй ойн дагалт нөөцийг ашиглах эрхийн бичгийг бусдад олгох тохиолдолд тэдгээр нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагатай урьдчилан тохиролцож, гэрээ байгуулсаны үндсэн дээр олгоно.” гэж заасны дагуу гэрээ байгуулсан аж ахуйн нэгжид энэ журмын 2.8, 2.12-т зааснаар эрхийн бичгийг 2 хувь үйлдэж орон нутгийн төсөвт орлогыг бүрэн төвлөрүүлсэн болно.

Иймд “Хуш модны самар үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэж гэрээ байгуулсан аж ахуй нэгж, байгууллагад ногдуулсан төлбөрийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй гэсэн дүгнэлтийг хасч өгнө үү.



Ц.МӨНХНАСАН

**Холбогдох байгууллагын саналын дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ:**

Аймгийн Аудитын газраас “Булган, Жаргалант, Хотонт, Төвшрүүлэх, Цэнхэр, Эрдэнэбулган, Тариат, Ихтамир сумын 2015, 2016 онд хуш модны самар үйлдвэрийн зориулалтаар бэлтгэсний төлбөр хураамжийг төсөвт төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалтын үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд аймгийн Засаг даргаас ирүүлсэн саналыг судалж үзээд дараах арга хэмжээг авлаа.

1. “... гэрээ байгуулсан аж ахуйн нэгжид “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам”-ын 2.8, 2.12-т зааснаар эрхийн бичгийг 2 хувь үйлдэж орон нутгийн төсөвт орлогыг бүрэн төвлөрүүлсэн болно. Иймд “Хуш модны самар үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэж гэрээ байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагад **ногдуулсан** төлбөрийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй гэсэн дүгнэлтийг хасч өгнө үү” гэсэн саналыг хүлээн авч “ногдуулсан орлого” гэснийг “гэрээнд заасан орлого” гэж өөрчлөн аудитын дүгнэлтийг “хуш модны самар үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх гэрээг дүгнээгүй, хэрэгжилтийг хангуулаагүй, зардлын 34.8 хувийг үр ашиггүй зарцуулсан байна” гэж өөрчилсөн болно.

-----OO-----



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА  
АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/14

Цэцэрлэг

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалын 5 дахь заалт, 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн ИТХурлын саналын дагуу "Архангай аймгийн Булган, Жаргалант, Хотонт, Төвшрүүлэх, Цэнхэр, Эрдэнэбулган, Тариат, Ихтамир сумын 2015, 2016 онд хуш модны самар үйлдвэрийн зориулалтаар бэлтгэсний төлбөр хураамжийг төсөвт төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалтын үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн акт, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.
3. Аудитын тайланг УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар, аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ахлах аудитор /Д.Нэргүйбаатар/-т даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.УЛАМБАЯР



D:\ALBAN TOOT\tushaal-2.doc

Архангай аймгийн Аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудиторовын 2017 оны 08 сарын 28 өдрийн 424  
дугаар тушаалын хавсралт

### Акт, албан шаардлагын жагсаалт

| № | Акт, Албан шаардлагын                                                                                                                                                                                                                                 |                            | Акт, Албан шаардлагыг<br>хэрэгжүүлэх<br>байгууллагын нэр |
|---|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------|----------------------------------------------------------|
|   | Зөрчлийн утга                                                                                                                                                                                                                                         | Мөнгөн<br>дүн<br>/сая.төг/ |                                                          |
| 1 | Цэнхэр сумын 2015 оны давсан орлогыг 2016 онд зарцуулахдаа хөрөнгө оруулалтын ажилд харьцуулалтын арга хэрэглээгүй шууд гэрээ байгуулсан, ажлын гүйцэтгэл хангалтгүй, чанаргүй хийгдсэн, үр ашиггүй, үр дүнгүй зарцуулсанд албан шаардлага хүргүүлсэн | 107.4                      | Цэнхэр сумын ЗДТГазар                                    |
| 2 | Цэнхэр сумын ЗДТГазраас 2012 оны 11 сард ажилтнуудад гар утасны нэгж олгосонд төлбөрийн акт тогтоосон                                                                                                                                                 | 1.7                        | Цэнхэр сумын ЗДТГазар                                    |
| 3 | Хотонт сумын Соёлын төвийн их засварын ажлыг хүлээн авсан комиссын актгүй, гэрээ дүгнээгүйд мөн төсвийн хөрөнгийг үр дүнгүй, үр ашиггүй зарцуулсанд албан шаардлага хүргүүлсэн                                                                        | 23.3                       | Хотонт сумын ЗДТГазар                                    |
| 4 | Ихтамир сумын Соёлын төвд худалдан авсан хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй, золбин нохой устгах ажлын гэрээ байгуулаагүйд албан шаардлага хүргүүлсэн                                                                                                | 2.5                        | Ихтамир сумын ЗДТГазар                                   |
| 5 | Сумын халуун усны түлш халаалтын зардал, цаг уурын ажилтны гар утасны төлбөрт 1.6 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсанд албан шаардлага хүргүүлсэн                                                                                                     | 1.6                        | Булган сумын ЗДТГазар                                    |